



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/107

Цагаан-Уул сум

Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил хийгдсэн газрын ойн санд үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.12 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2.4, 18.2.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа “Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашилан тэмцэл”-ийн ажлын явуулсан Тосон, Хужирт, Шарга багийн нутаг Улаанбулаг, Майхан, Манхан, Үст, Толь, Өвөр ганга, Зогдоо, Шавартбулаг нэртэй газрын ойн санд 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд мод бэлтгэх, мал бэлчээх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосугай.

2. Хориглосон хугацаанд захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг сумын Байгаль орны мэргэжилтэн (Ч.Эрдэнэчулуун), Байгаль хамгаалагч (Б.Батсуурь), (Н.Пүрэвбат), багийн Засаг дарга (Н.Доржпалам), (Ч.Дэрмэн), (Б.Бямба-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ОРЛОГЧ ДАРГА



У.АВАРЗЭД

/Zahiramj 2024/